

Алтан сав нээхүй: - Өөд болоочийг нутаглуулах зүгийн тухай

Дамдинсүрэнгийн ДАВААСҮРЭН*
Монгол улс, Улаанбаатар,
Соёл Урлагийн Их Сургууль,
Театр урлагийн сургууль

Received: Aug 17, 2025 | **Revised:** Oct 21, 2025 | **Accepted:** Dec 21, 2025

Хураангуй: Энэхүү өгүүлэлд өөд болоочийг нутаглуулахад баримтлах зүгийг хэрхэн тогтоодог болохыг тухайлан авч үзэв. Ингэхдээ бидэнд хадгалагдаж буй төвөд эрдэмтэн Санжаажамц (1653-1705)-ын зохиол *phug lugs rtsis kyi legs bshad mkhas pa'i mgul rgyan beet'ur dkar po'i do shal dpyod ldan snying nor zhes bya ba bzhugs so* (төвөд модон бар, цаасны хэмжээ: 10.3x48.2 см, хуудасны тоо: - 636, мон. *Пүг ёсны зурхайн сайн номлол мэргэдийн хоолойн чимэг Биндэргаравын унжлага шинжлэл төгсийн зүрхний эрдэнэ*) нэрт номын 343-418 дахь талд буй Үхэгсдийн зурхайн 29 дүгээр бүлэг, монгол эрдэмтэн Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788)-ын зохиол *gnyis pa gson gshin gang la ni, phan byed gshin rtsis gser snod bcas, dur lnga ngos 'dzin la sogs pa, phyogs gcig tu ni re'u mig 'god* (төвөд гар бичмэл, цаасны хэмжээ: 8.7x26 см, хуудасны тоо: - 17, мон. *Хоёрдугаар амьд, үхсэн алинд нь туслан үйлдэх үхэгсдийн зурхай Алтан сав сэлт, таван үхээрийг танин барих тэргүүтнийг нэг зүгт хүснэгтэд зохиовой*), монгол эрдэмтэн Лувсандагданы зохиол *gshin rtsis mdor bsdus 'khyir bde kun phan zhes bya ba bzhigs so* (төвөд гар бичмэл, цаасны хэмжээ: 9.8x42 см, хуудасны тоо: - 26, мон. *Үхэгсдийн зурхайн товч хураангуй Авахад хялбар бүхнээ туслагч*) хэмээх номыг голлон ашиглав.

Эдгээрээс гадна, үхэгсдийн зурхайн онолын ном бүтээлээс чухал хэрэгтэйг түүвэрлэн, хэрэглэхэд хялбар болгосон, эмхэтгэгч нь тодорхойгүй *beet'ur dkar po'i gshin brtsis mdor bsdus mdo gzhung bzhugs so* (төвөд гар бичмэл, 8.6x32 см, хуудасны тоо: - 16, мон. *Биндэргаравын үхэгсдийн зурхайн товч хураангуй Судрын гол оривой*), *Алтан сав хэмээх судар оривой* (монгол гар бичмэл, цаасны хэмжээ 8.5x30.6, хуудасны тоо: - 21), *gson pa bgegs bral dang gshin brtsis bzhugs so* (төвөд гар бичмэл, цаасны хэмжээ 18x7.5 см, хуудасны тоо: - 24, мон. *Амьдыг тотгороос хагацаах болон Үхэгсдийн зурхай оривой*), *gshin rtsi'i rnam bzhag mdor bsdus bya tshul gs'al byed me long zhes by aba bzhugs so* (төвөд гар бичмэл, хуудасны тоо: - 9, мон. *Үхэгсдийн зурхайн тийн агуулгын товч хураангуй Ажил үйлдвэрийг тодруулан үйлдэгч толь хэмээх оривой*), *gshin rtsi'i bzhugs so* (хүснэгттэй, төвөд гар бичмэл, хуудасны тоо: - 4, мон. *Үхэгсдийн зурхай*) зэрэг судалгааны хэрэглэгдэхүүн бидэнд хадгалагдаж байна.

* © Д.Даваасүрэн 2025
Email: davaasurend810@gmail.com

“Алтан сав нээх” эл зан үйлийг илт мэдэл эрхшээсэн нэгэн үйлдэх учиртайг зурхайч нь араасаа хэн нэгнийг чагнаж, түүний хэлснийг өмнөх хүндээ дамжуулж байгаа шиг төрх байдлыг үзүүлдэг ёс баталж байна.

Алтан савыг амьд, үхсэн хоёрт хоёуланд нь туслахын тулд нээдэг болох нь өгүүлэлд ашигласан эх хэрэглэгдэхүүн, тэдний гарчиг, нэн ялангуяа өөд болоочийг нутаглуулах зүгийг тогтоох агуулгаас тодорхой байна.

Сүмбэ хамба Ишбалжир, Лувсандагдан нарын энэхүү өгүүлэлд ашигласан зохиолын төгсгөлийн үгээс өөр, өөрийн нутагт өмнө дэлгэрсэн, уугуул ард түмний язгуур болон уламжлалт соёлыг даган баримталж, оршуулах ёслолыг журамладаг байсан нь тодорхой байна. Тийм ч учраас өөд болоочид болон түүний ар гэрийнхэнд туслах зорилготой алтан сав нээх гарын авлагын бичмэл хувилбар олон янз байдаг байна.

Түлхүүр үг: Үхэгсдийн зурхай, Сүмбэ хамба Ишбалжир, Лувсандагдан, Хар нохойн ам, Жийлэн, Төрсөн жил, Суусан суудал, Эрхиээсэн мэнгэ, Буусан мэнгэ, Хар мэнгэ, Шарил хөдөлгөх зүг, Нутаглуулах зүг

Opening of the “Altan sav”: about burial directions of the deceased person

DAVAASUREN Damdinsuren
Mongolian National University of Arts
and Culture, Ulaanbaatar, Mongolia

Abstract: This article provides a comprehensive explanation of the method for determining the burial direction of a deceased person. We primarily referenced the following scriptures:

- The 29th chapter, titled "The Horoscope of the Deceased" on pages 343-418 of the famous book "The good teachings of the Pug traditional astrology, the adornment of the wise, the pendant of Bindergarav, the treasure of the heart of the perfect astrologer" printed by the Tibetan wooden matrix (paper size 10.3x48.2, pages ...) by Tibetan scholar Sanjaijams.

- The Second Book "Rules compiled into a single table for Right recognition of "Altan sav" (Golden Box) and the Five kinds of Dead Body and horoscope of the deceased, which helps both the living and the deceased" (Tibetan manuscript, paper size 8.7x26, 17 pages) by the Mongolian scholar Sumbe Khamba.

- The Book "Brief Summary of the Horoscope for the Deceased, an Easy-to-Get Helper for All" (Tibetan manuscript, paper size 9.8x42, 26 pages) by the Mongolian scholar Luvsandagdan.

In addition to these, we have selected and made easy to use the most important research materials on the theory of the Horoscope of the deceased person:

- beet'ur dkar po'i gshin brtsis mdor bsdus mdo gzhung bzhugs (Author unknown, Tibetan manuscript, paper size 8.6x32, 16 pages).

- Bindergarav's summary of the Horoscope of the deceased, the main scripture

- The "Altan sav Sutra" (Mongolian manuscript, paper size 8.5x30.6, 21 pages).

- *The scripture "Protecting the Living from misfortunes and the Horoscope of the Deceased" (Tibetan manuscript, paper size 18x7.5, 24 pages).*
- *A summary of the contents of the horoscope of the deceased, a dictionary of proceedings of the work gshin rtsi'i rnam bzhag mdor bsdus bya tshul gsal byed me long zhes by aba bzhugs so (Tibetan manuscript, 9 pages).*
- *A summary of the contents of the horoscope of the deceased, a glossary of tasks to be done, and a guide to the rules of conduct, gshin rtsi'i bzhugs so (Tibetan manuscript with tables, 4 pages)*
- *Horoscope of the deceased (Mon).*

The ritual known as "Opening of the Altan sav" is conducted by a person possessing a profound understanding of the topic, akin to an astrologer who appears to be obtaining insights from an invisible entity and relaying them to the person before him.

It is evident from the original materials referenced in the article, their title, and particularly from the context surrounding the identification of the deceased's direction, that the purpose of "Opening of the Altan sav" is to assist both the living and the deceased.

The concluding remarks of the texts referenced in this article by Sumbe Khamba Ishbaljir and Luvsandagdan clearly indicate that they adhered to the traditions and cultural practices of the indigenous people who were dominant in their region, which governed their funeral rites. As a result, there are various written versions of the guide for "Opening of the Altan sav," created to assist the deceased and their families.

Key words: *Horoscope of the Deceased, Sumbe Khamba Ishbaljir, Luvsandagdan, Black Dog's Mouth (Method for finding a bad direction of the year and month, day), Year of Birth, Sitting Seat, Empowered Mole, Descended Mole, Black Mole, Direction of Moving the Dead body, Direction of burial place*

1. Удиртгал

Энэхүү өгүүлэлд, өөд болооч (нас барагч, бурхан болооч, талийгаач)-ийг нутаглуулахад баримтлах зүгийг хэрхэн тогтоодог болохыг тухайлан авч үзэв.

Зүгийг тогтоохдоо төрсөн жил, түүний амин махбодод тулгуурладаг. Төрсөн жилийн амин махбод нь тухайн жил аль суудалд суудгаас хамаарч, тогтмол байдаг. Тухайлбал бар, туулай хоёр зүүн зүгийн модон суудалд суудаг. Тэдний амин махбод нь мод мөн. Тиймээс өөд болооч бар жилтэй бол “зүүн зүгт сайн, хойно дунд, урд адаг, дөрвөн завсарт муу тул гэвч” гэжээ. Энэ нь тухайн хамаарах суудлын буян хишгийн зүгт хөдөөлүүлбэл хамгийн сайн, цог хийморийн зүгт бол дунд зэрэг, амин зүгт бол адаг буюу болохын төдий. Харин дөрвөн завсар буюу сайн зүгээс эм ороод бие тасрах, хорлол, шуламс, таван зэтгэрийн зүгт нутаглуулахыг цээрлэдэг байна.

Бас тухайн өөд болоочийг нутаглуулах зан үйлийг үйлдэх улирлын үүднээс нутаглуулах зүгийг нягталдаг. Тодруулбал, хаврын эхэн сард баруун хойд зүгт шарил гаргавал, гурван хүүр ирнэ. Дунд сард зүүн урд зүгт бол дөрвөн хүүр ирнэ. Адаг сард баруун зүгт гаргавал хоёр хүүр ирнэ гэх мэтээр тухайн улирлын аль сард уг зан үйлийг үйлдэхээс хамаарч цээртэй зүгийг нягтална. Үүнийг чанд баримтална. Өөрөөр хэлбэл,

нохой жилтэй хүн хаврын эхэн сард өөд болсон тохиолдолд, төрсөн жилийн үүднээс түүнийг баруун хойд зүгт нутаглуулах нь хамгийн сайн боловч, улирлын цээртэй зүг тул дунд, адаг гэх бусад хөдөөлүүлж болох зүгээс сонгоно.

Өөд болоочийг нутаглуулах зан үйлийн үест зүгийг харгалзан үздэг өөр тохиолдол бол түүнийг нутаглуулахаар авч явахдаа шарилыг анх аль зүгт хөдөлгөхийг урьдаар тогтдог. Энэ нь уг зан үйлийг өдрийн муу зүгийг төөрүүлж, суудлын муу зүгийг дагуулдаг. Энэ нь өдрийн муу зүгийг хар нохойн ам, жийлэн тоолж мэдээд, тэр зүг рүү эхлээд хөдлөхөөс сэргийлнэ. Харин өөд болоочийн тухайн жил сууж байсан суудлын бие тасрах, эсхүл хорлол, таван зэтгэрийн аль нэг рүү эхэлж мөр гаргадаг ёс бий.

Бид өөд болоочийн зурхай судлалын хүрээнд “Алтан сав нээхүй” (Зурхай судлалд-II) хэмээх нэг сэдэвт номыг 2009 онд хэвлүүлж, улмаар “Аман эш ба Алтан сав нээхүй” (2018), “Оршуулгын зан үйл, түүний эргэн тойронд” (2022), “Зүг ба цагийн цээрийг эрхэм болгохын учир” (2022), “Ша меса Содовын “Бүхнээ туслагч” хэмээх зурхайд холбогдох нэгэн зохиолын тухай” (2023), “Монголчуудын оршуулгын зан үйл дэх ил тавих ёсны тухайд” (2023) зэрэг сэдвээр эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж, өгүүлэл хэвлүүлээд байна.

Энэ удаагийн “Алтан сав нээхүй: Өөд болоочийг нутаглуулах зүгийн тухай” сэдэвт өгүүлэл нь өөд болоочийг нутаглуулах болон түүний шарилыг тээвэрлэхдээ суудал, билгийн улирал, шинийн өдрийн үүднээс зүгийг баримтлахад, хот суурины талаас тулгамдаж буй асуудлыг шийдэхэд практик ач холбогдолтой гэж үзэж байна.

2. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Өөд болооч болон ар гэрийнхний чулуу тавих буюу үхэгсдийн зурхайн жил, сар, өдөр, цаг, суудал, зүгийн сайн мууг шинжих үзлэг тэргүүтэн тооцох, ажиглах, асуух, нэгтгэн дүгнэх аргууд, мөн алтан сав нээх, өөд болоочийг хөдөөлүүлэх гэх соёлын зан үйл дэх уламжлалт мэдлэгийг герменевтикийн, хэлний соёл судлалын, хэл шинжлэлийн тайлан тайлбарлах, нэн ялангуяа эх бичгийн түгээмэл аргуудыг ашиглан, энэхүү өгүүллийг дараах эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан боловсруулав. Үүнд:

1. Санжаажамц (төвөд эрдэмтэн) phug lugs rtsis kyi legs bshad mkhas pa'i mgul rgyan beet'ur dkar po'i do shal dpyod ldan snying nor zhes bya ba bzhugs so (мон. *Пүг ёсны зурхайн сайн номлол мэргэдийн хоолойн чимэг Биндэргаравын унжлага шинжлэл төгсийн зүрхний эрдэнэ*), төвөд модон бар, цаасны хэмжээ 10.3x48.2 см, хуудасны тоо: - 636. 343-418 дахь талд буй Үхэгсдийн зурхайн 29 дүгээр бүлэг;
2. Ишбалжир (монгол эрдэмтэн, Сүмбэ хамба) gnyis pa gson gshin gang la ni, phan byed gshin rtsis gser snod bcas, dur lnga ngos 'dzin la sogs pa, phyogs gcig tu ni re'u mig 'god (мон. *Хоёрдугаар амьд, үхсэн алинд нь туслан үйлдэх үхэгсдийн зурхай Алтан сав сэлт, таван үхээрийг танин барих тэргүүтнийг нэг зүгт хүснэгтэд зохиовой*), төвөд гар бичмэл, цаасны хэмжээ 8.7x26, хуудасны тоо: - 17;
3. Лувсандагдан (монгол эрдэмтэн) gshin rtsis mdor bsdus 'khyir bde kun phan zhes bya ba bzhigs so (мон. *Үхэгсдийн зурхайн товч хураангуй Авахад хялбар бүхнээ туслагч*), төвөд гар бичмэл, цаасны хэмжээ 9.8x42, хуудасны тоо: - 26;

Мөн дээрх эх хэрэглэгдэхүүнд буй мэдээллийг дараах гарын авлагатай тулган нягтлав. Үүнд:

1. *beet'ur dkar po'i gshin brtsis mdor bsdus mdo gzhung bzhugs so* (төвөд гар бичмэл, 8.6x32 см, хуудасны тоо: - 16, мон. *Биндэргаравын үхэгсдийн зурхайн товч хураангуй Судрын гол оршвой*);
2. *Алтан сав хэмээх судар оршвой* (монгол гар бичмэл, цаасны хэмжээ 8.5x30.6 см, хуудасны тоо: - 21);
3. *gson pa bgegs bral dang gshin brtsis bzhugs so* (төвөд гар бичмэл, цаасны хэмжээ 18x7.5 см, хуудасны тоо: - 24, мон. *Амьдыг тотгороос хагацаах болон Үхэгсдийн зурхай оршвой*);
4. *gshin rtsi'i rnam bzhag mdor bsdus bya tshul gsal byed me long zhes by aba bzhugs so* (төвөд гар бичмэл, хуудасны тоо: - 9, мон. *Үхэгсдийн зурхайн тийн агуулгын товч хураангуй Ажил үйлдвэрийг тодруулан үйлдэгч толь хэмээх оршвой*);
5. *gshin rtsi'i bzhugs so* (хүснэгттэй, төвөд гар бичмэл, хуудасны тоо: - 4, мон. *Үхэгсдийн зурхай*)

Эх хэрэглэгдэхүүний хувьд төвөд, монгол бичгийн, Санжаажамц болон Лувсандагдан нарынх онолын, Сүмбэ хамба Ишбалжир болон эмхэтгэгч нь тодорхойгүй бусад гарын авлага нь өдөр тутмын хэрэглээнд зориулсан түүвэр тэмдэглэл юм.

Монгол эрдэмтэн Лувсандагданы талаар анх гэвш Ш.Иштавхай “Ша мэса Совд хэмээн алдаршсан тэрээр ...Шива ширээт номын багшийнхаа зарлигаар нутгийнхаа Нарангийн энгэр хэмээх газар сууж зохиол бүтээлээ туурвисан ариун гэлэн хүн... зохиол бүтээлийнхээ төгсгөлд өөрийнхөө алдрыг Бэхчү чанди хэмээн санскрит хэлээр тэмдэглэдэг.. Ша мэса гэдэг нь мах иддэггүй гэсэн утгатай түвд үг” (Иштавхай, 2006: 44) хэмээн мэдээлжээ.

3. Судалгааны хэсэг

Алтан сав нээх зан үйл дэх зүг тооцох арга аргачлал

Дэсрид Санжаажамцын тэмдэглэснээр: “*жил, сарын газрын хортон эзэн болон хоног, цагийн газрын эзэн орших (-руу) бүү гарга. Тэнгэр, лус, хортон орших газрыг тэвч. Хэрвээ эс чадвал түйтгэрийг зас*”⁹ (383а талын 4 дэх мөрд) гэсэн байна. Тодруулбал эл эшлэлд:

1. Шарилыг анх хөдөлгөх зүг;
2. Өөд болоочийг нутаглуулах өдөр;
3. Өөд болоочийг нутаглуулах зүг гэх гурван агуулга байна.

Газрын эздийн орших зүгийн талаар дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл Биндэргаравын 31 дэх бүлэг (441а-480б)-ийг, товч тодорхой мэдэхийг хүсвэл Лувсандагданы “**Үхэгсдийн зурхайн товч хураангуй Авахад хялбар бүхнээ туслагч**” нэрт гарын авлага дахь “*Шарил гаргах зүг, цагийг үзүүлэх нь*” (тө. Ro gtong phyogs dus bstan pa ni), “*Газрын эздийн орших зүг нь*” (тө. Sa bdag de rnamс gнас phyogs ni) гэх хоёр хэсгээс үзэж болно.

⁹ Төвөд: lo zla'i sa bdag gdur can dang, zhag dus sa bdag gнас mi gton, lha klu gdug can gнас sar spang, gal te mthu med sgrib shing bcos

Дэсрид Санжаажамцын зохиолоос татсан эшлэл дэх мэдээллийг бусад судалгааны эх хэрэглэгдэхүүнд шүүн үзвэл, тухайлбал Лхамцүлтэм “*жил, сар, хоног, цагийн газрын эзэн оршоогүй ариун зүгт, гариг, од хийгээд шинийн өдөр, суудал, мэнгэний буянтайд гарга. Ер нь суудлын дөрвөн сайн дээр, өөрт болон эхэд өлзийтэй*”¹⁰ (1995: 84-85) хэмээн тэмдэглэжээ. Өдгөө Улаанбаатар төвтэй бүс нутагт түгээмэл хэрэглэж буй өөд болоочийг нутаглуулах зүгийг тогтоохдоо дээрх эшлэлд үндэслэхийн зэрэгцээ:

1. Төрсөн жил (өөд болоочийн),
2. Найман суудал (өөд болох жилээ сууж байсан гадаад суудал),
3. Есөн мэнгэ (өөд болоочийн төрсөн мэнгэ),
4. Дөрвөн улирал (өөд болоочийн нас барсан улирал)-ыг тус тус харгалзуулан тооцдог.

Төрсөн жил, найман суудал, есөн мэнгийг тооцох аргыг Цахар гэвш Лувсанцүлтэмийн *Махбодын зурхайн ёсны жилийн тотгорыг шинжих увдисын утгын хураангуй*-д тулгуурлан, өөд болоочийг нутаглуулах зүгийг эх сурвалж¹¹, гарын авлага¹²-ын агуулгад үндэслэн, 2025 оны модон луу жилийн өвлийн илүү адаг улаан үхэр сарын 22-ны шарагчин хонь өдөр өөд болсон, 1947 оны гал гахай жилтэй, 78 настай, 8 цагаан мэнгэтэй, уул суудалд сууж байсан эрэгтэй хүнээр жишээ авч, өмнөх 4 зүйлээр тодруулах болно.

Газрын эздийн орших зүгийн талаар дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл Биндэргаравын 31 дэх бүлэг¹³-ийг, товч тодорхой мэдэхийг хүсвэл Лувсандагданы гарын авлага дахь “*Шарил гаргах зүг, цагийг үзүүлэх нь*”, “*Газрын эздийн орших зүг нь*” гэх хоёр хэсгээс үзэж болно. Лам хувраг төдийгүй, малчдын дунд буурь сэлгэх, аян замд гарах, өөд болоочоо нутаглуулах зэрэг элдэв үйл үйлдэхийн тулд “*жил, сар, хоног, цагийн газрын эзэн оршоогүй ариун зүг*”-ийг тогтоохдоо хар нохойн ам (тө. gnam khyi), жийлэн (тө. byi leng) тоолох явдал түгээмэл байдаг. Хар нохойн амыг жил, сар, өдөр, цагаар тооцдог. Үүнд шинэ, хуучин хоёр ёс байдаг бөгөөд шинэ ёсыг нь баримталдаг. “*Шинэ ёсонд жил, сар, хоног, цаг дөрвийн өөрийн дээр толгой, их харшид сүүл*” (Даваасүрэн, 2008: 32) таарна гэж үздэг. Жийлэн нь билгийн тооллын тухайн сарын өдөрт тулгуурлан тооцдог хялбар арга юм. Тухайлбал зуны тэргүүн могой, намрын дунд тахиа, өвлийн адаг үхэр сарын шинийн нэгэнд хойд талд, хоёронд зүүн хойд талд, гурванд баруун хойно, дөрвөнд зүүн, таванд баруун, зургаанд зүүн урд, долоонд баруун урд, найманд урд, есөнд дахин хойд талд хүрч өмнөх адил хөөн, битүүн буюу 30-н хүртэл тоолдог (Хүснэгт 1. Жийлэн тоолох жишээ (Тахиа, Үхэр, Могой сар).

¹⁰ Төвөд: ro yis ‘dren phyogs lo zla zhag, dust shod sa bdag mi gnas pa’i, phyogs gtsang dag tu gza’ skar dang, tshe grangs spar sme dge bar gtong, spyir ni spar kha bzang bzhi’i thog, rang dang ma thog shis pa yin

¹¹ 1) Дэсрид Санжаажамц (1653-1705)-ын зохиол “*Пүг ёсны зурхайн номлол мэргэдийн хоолойн чимэг Цагаан биндэрьяа-н унжлага Шинжлэл төгсийн зүрхний зэндмэнэ*”. Уг онолын сурвалж нь Их хүрээнд бартай, 636 хуудас, нийт 32 бүлэгтэй. “*Үхэгсдийн зурхай*” нь 29 дүгээр бүлэг бөгөөд уг барын 343-419 дэх хуудсанд буй. 2) Лхамцүлтэмийн зохиол “*Хар зурхайн чулуу тавих үрийн номлол оривой*”. Уг онолын сурвалж нь БНХАУ-ын Гансу мужид 1995 онд хэвлэсэн. 3) Лувсандагдан (Шамэса Содов). “*Үхэгсдийн зурхайн товч хураангуй Авахад хялбар бүхнээ туслагч*”;

¹² Сүмбэ хамба. “*Хоёрдугаарт амьд, үхсэн алинд нь туслах үхэгсдийн зурхай Алтан хайрцаг сэлт таван хүүрийг танин барих тэргүүтнийг эмхэтгэсэн хүснэгт*”; 2) “*Биндэргаравын үхэгсдийн зурхайн товч хураангуй Судрын гол оривой*”; 3) “*Үхэгсдийн зурхай оривой*”; 4) “*Амьдыг тотгороос хагацаах болон Үхэгсдийн зурхай оривой*” эдгээр гар бичмэл болно.

¹³ Их хүрээнд барласан эхийн 441а талаас, 480б талд буй.

Хүснэгт 1. Жийлэн тоолох жишээ (Тахиа, Үхэр, Могой сар)

30		
22	24	23
14	16	15
6	8	7
28, 20, 12, 4	Тахиа, Үхэр, Могой	5, 13, 21, 29
2	1	3
10	9	11
18	17	19
26	25	27

Сүмбэ хамба Ишбалжир бээр таван махбодын онолд үндэслэн, төрсөн жилийн үүднээс өөд болоочийг аль зүгт хэрхэн нутаглуулах аргыг боловсруулсан. Тодруулбал, гахай жилтний хувьд “хойд зүг сайн, баруун дунд, зүүн адаг. Урд болон завсрын дөрвөн зүг муу”¹⁴ юм. Энэ нь амин махбод нь ус болох хулгана жилтэнд ч мөн ижил.

Харин Лхамцүлтэмийн “суудлын дөрвөн сайн дээр, өөрт болон эхэд өлзийтэй. Муу дөрвийг тэвч”¹⁵ гэснээр бол нутаглуулах зүгийг баруун гурав болон зүүн хойд зүгийн аль нэгийг сонгох шаардлагатай болж байна (Хүснэгт 2. 1947 оны гахай жилтний сууж байсан суудал).

Хүснэгт 2. 1947 оны гахай жилтний сууж байсан суудал

Шулмас	Хорлол	Амь
Бие тасрах	УУЛ	Эм
Буян хишиг	Таван зэтгэр	Цог хийморь

Дээрх төрсөн жил, найман суудлын хувьд дундаж зүг нь **баруун зүг** болно. Өөд болоочийг аргын тооллын 2025 оны 02 дугаар сарын 24, билгийн тооллын өвлийн илүү адаг сарын 26-ны хөх хулгана өдөр нутаглуулах тохиолдолд эл зүгт жил, сар өдрийн хар нохойн ам, жийлэн аль аль нь таарахгүй.

Эдгээрээс гадна өөд болоочийг нутаглуулахад дараах хоёр зүйлийг давхар асууж нягтлах нь зүйтэй. Тэр нь нэгдүгээрт Лхамцүлтэмийн “...ялангуяа галд сохор тэргүүтнийг тэвч. Шороонд хэлгий, хутгалуулсныг тэвч. Төмөрт бэтэгтэй, тураалаар үхсэнийг тэвч. Усан хаван, хор, мэсээр үхсэнийг огторгуйд тэвч. Усанд бөгтөр, чулуужих өвчнөөр үхсэнийг, удам нь тасарсан, хэл амаар үхсэнийг ууланд, зэрэмдэг, боомилсон, мэсээр үхсэнийг модонд гаргах, хийд галзуурч үхсэнийг нутаглуулахыг тэвч

¹⁴ Төвөд: byang phyogs rab, nub 'bring, shar tha ma. lho dang mtshams bzhir ngan pas 'dzem. За талын 4 дэх багананы 3 дахь нүд.

¹⁵ Төвөд: spar kha bzang bzhi'i thog, rang dang ma thog shis pa yin, ngan bzhi spang la. 1995, 85 тал.

тэргүүтний ялгаа заагийг эрхэмлэ”¹⁶, хоёрдугаарт Лувсандагданы гарын авлагад суудлын үүднээс өөд болоочийг нутаглуулах зүгийг тогтохдоо “өөд болооч болон шарил үүрэгчийн шуламсын зүгт шарилыг үл гаргах бөгөөд галд үхсэнийг усанд гаргаж болохгүй. Суудлын дайсанд шарил гаргах муу. Дайсанд нь морь, могойг усанд гаргаваас тахиа, бич жилтэнд ч муу гэдэг. Үхлийн ам эс тасрах аваас шамдлаар дайсан лугаа шарилыг гаргаж үйлдээрэй”¹⁷ гэх эдгээр юм.

Лхамцүлтэмээс эшилсэнд буй “гал”, “шороо” гэх тэргүүтэн нь тухайн суудлын байрших зүгээр буюу сохор хүнийг урд зүгт, хэлгий юм уу, хутга мэсэнд өртөж үхсэнийг баруун урд зүгт нутаглуулах нь цээртэй гэх мэтээр ойлгоно.

Өдгөө өөд болоочийн суусан суудлын бие тасрах тэргүүтэй дөрвөн муу зүгийнх нь аль нэг рүү анх хөдөлгөөд, ихэвчлэн нар зөв эргэх байдлаар тойрч явсаар нутаглуулах газарт хүргэж буйг Лувсандагданаас эш татсан “үхлийн ам эс тасрах аваас шамдлаар дайсан лугаа шарилыг гаргаж үйлдээрэй” гэсэнд үндэслэн, нэгэн бүл айлын хүмүүс дараалан нас барах зэрэг тохиолдлоос сэргийлж, үхлийн амыг хаах, таслахыг бэлгэдэж буй хэмээн тайлбарлах боломжтой байна.

Есөн мэнгэний үүднээс өөд болоочийг аль зүгт нутаглуулах тухай Биндэргаравын 29 дүгээр бүлэгт “зургаан цагаан, найман цагаан ер нь сайн. Ногоон, шар дунд, хар, хөх болон хоёр улаан ер муу”¹⁸, Лхамцүлтэм бээр “...төрсөн мэнгэ голд оруулсны гурван цагааны зүг сайн, хар хөхийг тэвч. Хоёр улаан муу, таван шар дунд”¹⁹ гэсэн байна. “Зургаан цагаан”, “найман цагаан” гэдгээр зүг зааж байна. Лувсандагданы “төвд мэнгэ алин болон алин хэмээх тэргүүтнийг зарлигласан тул өөд болоочийн амьдын төрсөн мэнгийг голд оруулан үсэргэн тооцвоос таарах буюу хэмээснийг шинжлээрэй”²⁰ гэх аргачлалаар дээрх зүгийг олно. Тодруулбал, өөд болоочийн төрсөн мэнгэ нь 8 цагаан (Хүснэгт 3. 1947 оны гахай жилтний төрсөн мэнгийг голлуулан мэнгэ үсэргэх) бөгөөд Лувсандагданы зөвшөөсөн тооцох аргаар бол:

Хүснэгт 3. 1947 оны гахай жилтний төрсөн мэнгийг голлуулан мэнгэ үсэргэх

7 улаан	3 хөх	5 шар
6 цагаан	8 ЦАГААН	1 цагаан
2 хар	4 ногоон	9 улаан

“Хүснэгт 3”-аас үзвэл, өөд болоочийг Биндэргараваас татсан эшээр зүүн, Лхамцүлтэмээс татсан эшээр баруун зүгт тус тус нутаглуулах нь сайн. Харин хойд болон баруун урд зүгт дунд, зүүн хойно болон урд, баруун хойно, зүүн урд зүгт муу байна. Энд

¹⁶ Төвөд: bye brag tu, li thog long zhar la sogs spang, khon la dig pa subs gri spang, du la skran can gri bo spang, dmu chu dug gri khen la spang, kham la sgur po rdel nad can, rabs chad phur khas shi ba gin, zha bo ‘gag gri zin gyi thog, zon thog smyon pa’i ro ‘dren spang, la sogs bye brag phyed pa sces. 1995, 85 тал

¹⁷ Төвөд: gshin dang ro khur bdud gcod kyi, phyogs su ro yang mi btang zhing, lir shi kham thog la mi gtong, spar kha dgra dur thog la ngan, dgra ni rta sprul kham btang na, bya sprel lo la ngan kyang zer, nan ltar shi kha ma chod na, dgra dang dur la btang bar bya. 136 талын 3-4 дэх мөрд.

¹⁸ Төвөд: drug dkar brgyad dkar sbyir ni bzang, ljang ser ‘bring la nag mthing dang, dmar gnyis spyir na ngan pa ste. 136 талын 3-4 дэх мөрд.

¹⁹ Төвөд: skyes sme dbus bcug pa’i dkar gsum phyogs bzang nag mthing spang, dmar gnyis ngan la lnga ser ‘bring. 1995, 85 тал.

²⁰ Төвөд: dbus sus me ba gang dang gang, zhes sogs gsungs phyir gshin gson gyi, skyes sme dbus bcug ‘phur brtsi na, ‘thad dam snyam ste dpyad par bya. 126 талын 3-4 дэх мөрд.

“Хар мэнгэ” (Хар мэнгэний талаар Биндэргаравын 29 дүгээр бүлэг, Их хүрээний барын судрын 383а, б, Лувсандагданы гарын авлагын 12б талын 4 дэх мөрөөс 13б талын 2 дахь мөрөөс тус тус үзэж болно) гэх ойлголтын талаас зүгийг давхар нягталдаг. Хар мэнгэ нь Лувсанцүлтэмийн тэмдэглэснээр “*есөн наснаас бага нялхсын хар мэнгэ нь нэг цагаан мөн. 18 хүртэлх залуусын хар мэнгэ нь гурван хөх мөн. 19-өөс дээш насны эрэгтэйчүүдийн хар мэнгэ нь хоёр хар мөн. Тэрчлэн бэлэвсэн эмэгтэйнх дөрвөн ногоон, тойн хуврагийнх таван шар, бөөгийнх зургаан цагаан, эхнэр хүнийх долоон улаан, ноёд түшмэдийнх найман цагаан, өндөр настны хар мэнгэ есөн улаан*”²¹ юм. Тодруулбал, өөд болоочийн төрсөн жил, найман суудлын үест дундаж зүг нь баруун зүг байсан. Эл зүгт 1 цагаан мэнгэ таарч байгаа бөгөөд Санжаажамцын онцлон тэмдэглэснээр “...*нэг цагаанд нялхсын хоёр хар мөн учраас нялхсыг хөдөөлүүлж болохгүй*”²².

Товчдоо, өөд болооч нь 78 настай. Тиймээс хар мэнгэ нь 9 улаан. “Хүснэгт 3”-аас үзвэл 9 улаан нь баруун хойд зүгт таарч байна. Энэ зүгт өөд болоочийг хөдөөлүүлж болохгүй. Тэгэхээр төрсөн мэнгийг голлуулан мэнгэ үсэргэх аргаар тооцсон уг аргын дүнд төрсөн жил, найман суудалтай ижил баруун нь сайн зүг байна.

Дөрвөн улирлын хувьд Биндэргаравт “*сард эргэх газрын эздийн мөн чанар нь муу зүг жаран дөрөв болон сарын хар, хоосон бумба, халчи, дочэ, эр эм намчи сэлтийн газрын эзэн оршсон, оршоогүйд харгалзахгүй муу зүг хаврын эхэн баруун хойш шарил гаргаваас гурван хүүр ирэх тул муу мөн, дунд зүүн урдад дөрвөн хүүр ирнэ, адагт баруунд гаргаваас хоёр хүүр ирнэ. Зуны эхэн урагш муу дөрвөн хүүр ирнэ, зуны дунд зүүн хойш гурван хүүр ирнэ, зуны адаг зүүнд таван хүүр ирнэ. Намрын эхэн зүүн урдад гурван хүүр ирнэ, намрын дунд баруун хойно хоёр хүүр ирнэ, намрын адаг чанх хойно малын хашаа хоосорно, эд агуурс барагдах болно. Өвлийн эхэн баруун хойш мал хуй гарч, хоёр хүн үхэх тул мууд мэд, өвлийн дунд баруун урагш эхнэр болон нялх хүүхэд үхсэнд муу, адагт чанх баруун зарга, хэл ам тасрахгүй гарна*”²³ (Санжаажамц. 455б талын 6 дахь мөрөөс, 456а талын 3 дахь мөрд).

Өмнөх төрсөн жил, суусан суудал, төрсөн мэнгийг голлуулан мэнгэ үсэргэсэн аргын үүднээс тогтоосон баруун зүг өвлийн адаг сарын хувьд сард эргэх газрын эздийн гүйдлийг эс тооцон, шарил нутаглуулахыг тэвчдэг зүг таарч байна. Тиймээс “*хэрэв шарил гаргахыг хүсэх аваас газар ухахгүй байхад шамдаж үйлдээрэй. Басхүү байшны сууринд нууваас болно*”²⁴ (Санжаажамц. 456а талын 3 дахь мөрд) гэсний үүднээс холбогдох засал хийснээр гахай жилтнийг баруун зүгт хөдөөлүүлж болох юм. Заслын хувьд “*доройтвоос үрийн зүйлээр хүн хийгээд торгоны зүйлээр (чимэглээд) Найман гэгээнээр засваас чадна*”²⁵ (Санжаажамц. 456а талын 3 дахь мөрд) хэмээсэн байна.

Товчдоо, 2025 оны модон луу жилийн өвлийн илүү адаг улаан үхэр сарын 22-ны шарагчин хонь өдөр өөд болсон 1947 оны гал гахай жилтэй, 78 настай, 8 цагаан мэнгэтэй,

²¹ Төвөд: lo dgu man gyi byi pa'i sme nag ni gcig dkar yin, lo bco brygad bar gyi khye'u yi sme nag nig sum mthing yin, bcu dgu yan gyi mi pho'i sme nag ni gnyis nag yin no. de bzhin tu yugs mo'i bzhi ljang, rab byung gi lnga ser, bon po'i drug dkar, bud med kyi bdun dmar, rje dponn gyi brygad dkar, rkan rkon gyi sme nag ni dgu dmar ro. 34б талын 8 дахь мөрөөс, 35а талын 4 дэх мөрд.

²² Төвөд: gcig dkar la, byis pa'i gnyis nag yin pas na, byis pa'i ro ni mi btang ngo. 383а талын 4 дэх мөрд.

²³ Төвөд: zla bar 'khor ba'i sa bdag ni, ngan phyogs ngo bo re bzhi dang, zla nag bum stong khal lto 'phye, gnam khyi pho mo dang bcas pa'i, sa bdag gnas dang mi gnas la, ltos pa med par ngan pa'i phyogs, dpyid ra nub byang ro drangs na, rog sum 'ong pas ngan pa yin, 'bring po shar lhor ro bzhi 'ong, tha chung nub drangs ro gnyis 'ong, dbyar ra lhor ngan ro bzhi 'ong, dbyar 'bring byang shar ro gsum 'ong, dbyar tha shar du ro lnga yod, ston ra shar lhor rog sum 'ong, ston 'bring nub byang ro gnyis zlos, ston tha byang mthil phyugs ra stongs, nor god chad pa dbab par 'gyur, dgun ra nub byang phyugs sna drangs, mi gnyis 'chi bas ngan bar shes, dgun 'bring lho nub bud med dang, du'u 'chi bar 'gyur bas ngan, tha chung nub mthil zhal che dang, kha smras rgyun mi chad pa 'byung

²⁴ Төвөд: gal te rog tong 'dod pa na, sa mi brgo bar bad pa bya, yang nak hang rmang spas pas thub

²⁵ Төвөд: nyams na 'bru sna'l mi dang ni, dar sna snang brygad kyis bcos thub

уул суудалд сууж байсан эрэгтэй хүнийг баруун зүг рүү хөдөөлүүлж болох бөгөөд шороонд буюу ил тавих хэлбэрээр оршуулж болохоор байна.

Дэсрид Санжаажамц тэргүүтний айлдсан онолын эх сурвалж, Сүмбэ хамба Ишбалжир тэргүүтний нийт монголчуудын болон тодорхой угсаатны бүлгийн соёл, соёлын зан үйлд нийцүүлэн журамласан алтан сав нээх элдэв гарын авлагуудын үүднээс “*өөд болоочийн амь, бие, эртхэн, хийморь дөрвөөр огторгуйн жил, сар, өдөр, цаг дөрөвт харгуулсан 16 чулуу*”²⁶ (Лхамцүлтэм, 1995: 60)-ны үрийг сайтар шинжилсний үрд нэг талаасаа өөд болооч, нөгөө талаасаа түүний ар гэрийнхэнд тустайгаар шийддэг болохыг онцлон тэмдэглэж байна. Чулуу тавихын тухайд ч зөвхөн 16 чулуугаар хязгаарлагдахгүй мэнгэний тотгор (тө. sme keg), өөрийн түйтгэр (тө. rang keg) тэргүүтэн ширүүн долоо (тө. bdun zur), урвасан жил (тө. log min), өөдлөх уруудах (тө. dar rgud bcu gnyis), есөн нүд (тө. dgu mig), бага харш (тө. gshid bzhi) тэргүүтнийг нэмсэн нэгэн хувилбар; Өөд болоочийн төрсөн жил (тө. skyes lo)-тэй огторгуйн жил (тө. gnam lo), урвасан жил, суудал (тө. spar kha), буусан мэнгэ (тө. babs sme), өөдлөх уруудах, сар (тө. zla ba), хоног (тө. zhag), цаг (тө. dus), гариг (тө. skar ma), од (тө. skyu skar), ар гэрийнхний нэгний жилийг харгуулсан хоёр дахь хувилбарын аль нэгийг буюу тухайн нутаг оронд дэлгэрсэн аргачлалын дагуу 50 чулуу тавьснаар оршуулгын зан үйлийг заан хөтөлдөг.

4. Дүгнэлт

Эцэст нь дараах хэдэн зүйлийг онцлохыг хүсэж байна. Үүнд:

1. “Алтан сав нээх” хэмээх эл зан үйлийг номын ном үзэж ухааны сүв нээгдсэн нэгэн нээх боломжтой боловч, илт мэдэл эрхшээсэн нэгний үйлдвэр мөн болох нь “*би хөвгүүн, охиндоо золгоё хэмээн өгүүлэх, эм (бол) хөвгүүндээ сэтгэл минь тачаамуй. Би улаан саван доторх идээнд тачаамуй*” (Алтан сав хэмээх судар оршвой. 4б талын 9-12 дахь мөрд), эсхүл “*том хүү байваас уулзахыг хүсэж байна гэлээ, хоолны үлдэгдэл, цайны үлдэгдлийг биед одуул гэлээ*” (8б талын 5 дахь мөрд) гэх мэтээс тодорхой байдаг. Тиймээс алтан сав нээхдээ араасаа хэн нэгнийг чагнаж, түүний хэлснийг өмнөх хүндээ дамжуулж байгаа шиг төрх байдлыг үзүүлж байхыг багш нар захисан билээ.
2. Алтан савыг амьд, үхсэн хоёрт хоёуланд нь туслахын тулд нээдэг. Энэ нь онолын эх сурвалж болон өдөр тутам хэрэглэхэд зориулан дөхөмчилсэн гарын авлагуудын агуулга, нэр зэргээс тодорхой байна. Тиймээс Лувсанцүлтэм бээр хүмүүний насан туршийн үйлийн хувь сайн, мууг шинжих (1. тө. mi'i tshe ril po'i las bskaI bzang ngan brtag pa), Жил, сар тэргүүтний тотгорын зурхай (2. тө. lo zla sogs kyI keg rtsis), Бэрийн зурхай (3. тө. bag ma rtsis), Үхэгсдийн зурхай (4. тө. gshin po'i rtsis), Өвчин, адын зурхай (5. тө. nad gdon gyi rtsis), Газар шинжих (6. тө. sa dpyad), Газрын эзний орших, гүйхийн зурхай (7. тө. sa bdag gi gnas pa dang rgu ba'i rtsis)-н алийг боловч “*амьтанд туслахын сайн санаагаар алин таарахыг шинжлээд эш үзүүлэх хэрэгтэй*”²⁷. Зөвхөн зурхай ч биш, Бурхны шашны алив ухааны оронд хий хоосон алдар нэр, хэрэг тусгүй ашиг орлогын төлөөнөө суралцдаггүйг энэ дашрамд онцлоход илүүдэх зүйлгүй биз ээ.
3. Эдүгээ түгээмэл хэрэглэдэг Сүмбэ хамбын журамласан үхэгсдийн зурхайн гарын авлагын төгсгөлийн үгэнд “Үхсэний үйл үйлдвэр үүнд Биндэрьяа тэргүүтэнд

²⁶ Төвөд: gshin po'i srog lus dbang klung bzhis, gnam lo zla zhag dust shod bzhir, 'thab pas rde'u bcu drug

²⁷ Төвөд: skye 'gro la phan pa'i bsam pa bzang pos gang 'thad la dpyad nas lung ston dgos. 18б талын 7-8 дахь мөр.

өөрөө урласан олон тул төвөдийн урьдын дээдсийн ёсыг голлон үүнийг зохиов”²⁸, бас Лувсандагдан Биндэргаравын үхэгсдийн зурхайн бүлгийг баримтлан эмхэтгэсэн “**Үхэгсдийн зурхайн товч хураангуй Авахад хялбар бүхнээ туслагч**” нэрт гарын авлагынхаа төгсгөлд “энэ нь хэрэгт чухалчлагч олон бээр дуртгасны тул Биндэргарав болон дээдсийн таалал ямарчлан Вигчү шанди нэрт бээр авахад хялбараар байгуулсны бичээч шинжлэл төгс Лувсанбалдан болой. Үүгээр ч гаслант олонд тус агуу их үйлдэх болтугай”²⁹ (25б, 6 мөрөөс, 26а, 1-2 мөр) хэмээжээ. Сүмбэ хамба Ишбалжир, Лувсандагдан нарын дээрх төгсгөлийн үгээс өөрийн нутагт өмнө дэлгэрсэн, уугуул ард түмний язгуур болон уламжлалт соёлыг даган баримталж, оршуулах ёслолыг журамладаг байсан нь тодорхой байна. Тийм ч учраас өөд болоочид болон түүний ар гэрийнхэнд туслах зорилготой алтан сав нээх гарын авлагын бичмэл хувилбар олон янз байдаг байна.

Ном зүй

Монгол хэлээр:

Даваасүрэн, Д. (2008). *Өлзий хутагийн сайн найлзуур мод /зурхай судлал-I/* Улаанбаатар: Khaan хэвлэх үйлдвэр. [Davaasuren, D. Ulzii khutgiin sain nailzuur modon /horoscope study-I/, Ulaanbaatar, Khaan Publishing House. 2008].

Сумьяа, Б. (2021). Монголын нүүдэлчдийн соёл: Орших эс орших, УБ., Линограф хэвлэх үйлдвэр. [Sumya. B (2021). Mongolian nomadic culture: To be or not to be, Ulaanbaatar, Linograf Printing House.]

Тэрбиш Л. (2002). Үрийн зурхай болор толь, Улаанбаатар хот. [Terbish. L (2002). Crystal Dictionary of the Karma horoscope, Ulaanbaatar city.]

Төвөд хэлээр:

“Altan sav” (Golden pot) Sutra, Mongolian manuscript, paper size 8.5x30.6 cm, number of pages 21. In a private library.

Protection of the Living from Harm and Horoscope of the Deceased, Tibetan manuscript, paper size 18x7.5 cm, number of pages 24. In a private library.

Beetu’ur dkar po’i gshin brtsis mdor bsdus mdo gzhung bzhugs so (Mon. Summary of the Horoscope of the Deceased and the Main Sutra by Bindergarav), Tibetan manuscript, 16 pages. In a private library.

Luvsandagdan. A summary of the Horoscope of the Deceased. (An Easy-to-Get Helper for All), paper size 9.8x42, number of pages 26. In a private library.

²⁸ Төвөд: gshin las kyi by aba ‘di la bee d’ur sogs la rang bzo mang bas ‘dir bod snga rabs pa’I lugs gtso bor bkod. 17a. 5-7 мөр.

²⁹ Төвөд: ‘di ni don gnyer can, mang pos bskul phyir bee dkar dang, dam pa’i dgongs pa ji bzhin du, bhikshu kashanti’i ming can gyis, ‘khyir bder bkod pa’i yi ge pa, dpyod ldan blo bzang dpal ldan no, ‘dis kyang nyam thag mang po la, phan pa rgya chen bskyed gyur cig. 25б. 6 мөрөөс, 26а. 1-2 мөр.

Luvsantsultem. ‘byung rtsis lugs kyi lo keg brtag pa man ngag don bsdus zhes bya ba bzhugs so (Mon. Summary of the meaning of magic used to analyze the troubles of the zodiac year of Body), Tibetan manuscript, paper size 8.7x21 cm, number of pages 41.

Lkhamtsultem. (1995). nag rtsis rdel ‘grem ‘bras bshad bzhugs so (Mon. A sermon on laying the black horoscope stone). Gansu Province.

Sanjaajamts. The sacred teachings of Astrology of the Pug order, the necklace of the White Binderya, and the heart's desire for perfection in analysis. Tibetan wooden matrix, paper size 10.3x48.2 cm, number of pages 636. In a private library.

The Horoscope of the Deceased (with tables), Tibetan manuscript, 4 pages. In a private library.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>